

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арван дөрөвдүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/121/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: Груут финанс аудит ХХК
Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж
Утас: 7772-1628
Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 56

танай _____-ны № _____-т

「АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН」
СУМЫН ХҮҮХДИЙН 14 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ч.ДОЛГОРСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 797,616.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 770,282.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------|--|-----------------|-----------------|
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 59,062,671.68 | 8,680,630.49 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 59,062,671.68 | 8,680,630.49 |
| 3121 | Төгрөг | 59,062,671.68 | 8,680,630.49 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 59,062,671.68 | 8,680,630.49 |
| 33 | АВЛАГА | | |
| 34 | УРЬДЧИЛГАА | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 61,063,229.99 | 56,312,090.62 |
| 351 | Түүхий эд материал | 186,000.00 | 186,000.00 |
| 3513 | Эм боох материал | 186,000.00 | 186,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 60,877,229.99 | 56,126,090.62 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 1,913,600.00 | 2,928,200.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 55,749,719.89 | 41,531,028.62 |
| 3545 | Барилгын засварын материал | 2,287,100.00 | 3,789,000.00 |
| 3546 | Хүнсний материал | 926,810.10 | 764,362.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | | 7,113,500.00 |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 120,125,901.67 | 64,992,721.11 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 68,067,446.05 | 78,517,374.35 |
| 392 | Биет хөрөнгө | 36,967,446.05 | 46,107,374.35 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 56,045,308.00 | 56,362,320.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (26,732,137.17) | (34,583,326.55) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,840,411.48 | 51,309,451.48 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (23,118,302.97) | (30,448,237.33) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,400,000.00 | 4,400,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (645,833.29) | (1,195,833.25) |
| 39217 | Ном | 178,000.00 | 263,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 31,100,000.00 | 32,410,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,417,500.00 | 1,320,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,417,500.00) | (10,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 31,100,000.00 | 31,100,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 68,067,446.05 | 78,517,374.35 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 188,193,347.72 | 143,510,095.46 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,419,000.00 | - |
| 413 | Өглөг | 1,419,000.00 | - |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 619,000.00 | - |
| 4136 | Бусад өглөг | 800,000.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 800,000.00 | - |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,419,000.00 | - |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 186,774,347.72 | 143,510,095.46 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 31,100,000.00 | 31,100,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | | |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 155,674,347.72 | 112,410,095.46 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 155,674,347.72 | 155,674,347.72 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | (43,264,252.26) |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 186,774,347.72 | 143,510,095.46 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 188,193,347.72 | 143,510,095.46 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|----------------|-----------------|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 68,285,200.00 | 740,385,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 596,779,000.00 | 668,845,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 596,779,000.00 | 668,845,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 71,506,200.00 | 71,540,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 71,506,200.00 | 71,540,200.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 19,369,500.00 | 45,328,600.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 19,369,500.00 | 45,328,600.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 140,000.00 | 140,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 140,000.00 | 140,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 19,229,500.00 | 25,215,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 19,973,600.00 |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 687,654,700.00 | 785,714,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 683,198,012.88 | 828,978,252.26 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 675,928,010.58 | 804,973,845.75 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 467,378,760.65 | 572,278,443.00 |
| 210101 | Үндсэн цалин | 42,046,973.65 | 381,362,930.00 |
| 210102 | Нэмэгдэл | 09,065,137.00 | 143,305,013.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 12,910,000.00 |
| 210104 | Урамшуулал | 16,266,650.00 | 34,700,500.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 58,193,832.35 | 71,287,791.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,093,830.50 | 49,194,429.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,715,814.74 | 5,779,803.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,344,128.86 | 3,025,510.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,208,868.74 | 2,647,752.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,831,189.51 | 10,640,295.14 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 52,707,297.70 | 44,454,893.49 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,974,475.00 | 8,513,487.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,373,600.20 | 32,790,665.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,359,222.50 | 3,150,741.09 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 12,860,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 12,860,100.00 |
| 2105 | Нормативт зардал | 46,569,382.00 | 50,860,655.10 |
| 210502 | Хоол, хүнс | 46,569,382.00 | 50,860,655.10 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,830,800.00 | 4,591,304.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,830,800.00 | 4,591,304.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,706,200.00 | 1,474,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,706,200.00 | 1,474,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,541,737.88 | 47,166,058.97 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,101,801.00 | 23,635,737.27 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,842,200.00 | 3,115,350.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 14,597,736.88 | 20,414,971.70 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,270,002.30 | 24,004,406.51 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,611,100.00 | 3,379,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,611,100.00 | 3,379,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,658,902.30 | 20,625,406.51 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,658,902.30 | 20,625,406.51 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 83,198,012.88 | 828,978,252.26 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 4,456,687.12 | (43,264,252.26) |

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арван дөрөвдүгээр цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-----|--|--------------|-----------------|
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | - |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 4,456,687.12 | (43,264,252.26) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|------------|--|----------------|--------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 668,425,200.00 | 740,525,400.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 140,000.00 | 140,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 140,000.00 | 140,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 140,000.00 | 140,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 140,000.00 | 140,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 668,285,200.00 | 740,385,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 596,779,000.00 | 668,845,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 596,779,000.00 | 668,845,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 71,506,200.00 | 71,540,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 71,506,200.00 | 71,540,200.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 669,559,644.10 | 785,257,541.19 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 669,559,644.10 | 785,257,541.19 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 662,289,641.80 | 761,253,134.68 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 466,376,724.00 | 575,061,635.60 |
| 210101 | Үндсэн цалин | 333,328,324.00 | 367,388,043.00 |
| 210102 | Нэмэгдэл | 116,877,912.00 | 160,063,092.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 12,910,000.00 |
| 210104 | Урамшуулал | 16,170,488.00 | 34,700,500.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 59,178,400.00 | 68,504,598.59 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,241,300.00 | 45,901,184.19 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,734,300.00 | 5,363,014.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,367,100.00 | 2,873,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,367,100.00 | 2,873,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,468,600.00 | 11,493,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 52,707,297.70 | 44,454,893.49 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,974,475.00 | 8,513,487.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,373,600.20 | 32,790,665.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,359,222.50 | 3,150,741.09 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | |
| 2105 | Нормативт зардал | 46,417,320.10 | 51,317,207.00 |
| 210502 | Хоол, хүнс | 46,417,320.10 | 51,317,207.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,140,000.00 | 5,986,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,140,000.00 | 5,986,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,706,200.00 | 1,640,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,706,200.00 | 1,640,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,763,700.00 | 14,287,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,152,600.00 | 9,445,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,611,100.00 | 4,841,800.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,270,002.30 | 24,004,406.51 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,611,100.00 | 3,379,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,611,100.00 | 3,379,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,658,902.30 | 20,625,406.51 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,658,902.30 | 20,625,406.51 |

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арван дөрөвдүгээр цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|---|----------------------|----------------------|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (1,134,444.10) | (44,732,141.19) |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 2,194,900.00 | 5,649,900.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 2,194,900.00 | 5,649,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,194,900.00 | 5,649,900.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (2,194,900.00) | (5,649,900.00) |
| 145 | Бусад эх үүсвэр | | |
| 25 | Санхүүгийн үйл ажиллагааны зардал | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (3,329,344.10) | (50,382,041.19) |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 62,392,015.78 | 59,062,671.68 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 59,062,671.68 | 8,680,630.49 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--------------------------------------|---------------------------------|----------------------|--|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 31,100,000.00 | 151,217,660.60 | 182,317,660.60 |
| 2 | Тайлант үеийн үр дүн | - | 4,456,687.12 | 4,456,687.12 |
| 3 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 31,100,000.00 | 155,674,347.72 | 186,774,347.72 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | - | (43,264,252.26) | (43,264,252.26) |
| 5 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 31,100,000.00 | 112,410,095.46 | 143,510,095.46 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Бүртгэлийн дансны код | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|-----------------------|----------------|-------------------|-----------------|--------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2 | 800,195,000.00 | 770,282,034.68 | 29,912,965.32 | 96.26 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 21 | 800,195,000.00 | 770,282,034.68 | 29,912,965.32 | 96.26 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 210 | 796,816,000.00 | 766,903,034.68 | 29,912,965.32 | 96.25 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2101 | 577,257,100.00 | 574,677,850.00 | 2,579,250.00 | 99.55 |
| Үндсэн цалин | 210101 | 367,161,000.00 | 367,161,000.00 | - | 100.00 |
| Нэмэгдэл | 210102 | 182,524,900.00 | 159,906,350.00 | 22,618,550.00 | 87.61 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 210103 | | 12,910,000.00 | (12,910,000.00) | |
| Урамшуулал | 210104 | 27,571,200.00 | 34,700,500.00 | (7,129,300.00) | 125.86 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2102 | 70,513,300.00 | 68,888,384.19 | 1,624,915.81 | 97.70 |
| Тэтгэврийн даатгал | 210201 | 47,526,100.00 | 45,901,184.19 | 1,624,915.81 | 96.58 |
| Тэтгэмжийн даатгал | 210202 | 5,746,800.00 | 5,746,800.00 | - | 100.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 210203 | 2,873,400.00 | 2,873,400.00 | - | 100.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 210204 | 2,873,400.00 | 2,873,400.00 | - | 100.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 210205 | 11,493,600.00 | 11,493,600.00 | - | 100.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2103 | 65,080,300.00 | 44,454,893.49 | 20,625,406.51 | 68.31 |
| Гэрэл, цахилгаан | 210301 | 13,482,000.00 | 8,513,487.00 | 4,968,513.00 | 63.15 |
| Түлш, халаалт | 210302 | 39,796,700.00 | 32,790,665.40 | 7,006,034.60 | 82.40 |
| Цэвэр, бохир ус | 210303 | 11,801,600.00 | 3,150,741.09 | 8,650,858.91 | 26.70 |
| Хангамж, бараа материалын зардал | 2104 | | | - | |
| Нормативт зардал | 2105 | 56,400,400.00 | 51,317,207.00 | 5,083,193.00 | 90.99 |
| Хоол, хүнс | 210502 | 56,400,400.00 | 51,317,207.00 | 5,083,193.00 | 90.99 |

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арван дөрөвдүгээр цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|--|---------------|-----------------------|-----------------------|----------------------|--------------|
| Эд хогшил, урсгал засварын зардал | 2106 | 6,459,900.00 | 6,459,900.00 | - | 100.00 |
| Урсгал засвар | 210604 | 6,459,900.00 | 6,459,900.00 | - | 100.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2108 | 3,027,600.00 | 3,027,500.00 | 100.00 | 100.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 210806 | 3,027,600.00 | 3,027,500.00 | 100.00 | 100.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 2109 | 18,077,400.00 | 18,077,300.00 | 100.00 | 100.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 210901 | 13,205,600.00 | 13,205,500.00 | 100.00 | 100.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 210902 | 4,871,800.00 | 4,871,800.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 213 | 3,379,000.00 | 3,379,000.00 | - | 100.00 |
| Бусад урсгал шилжүүлэг | 2132 | 3,379,000.00 | 3,379,000.00 | - | 100.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 213209 | 3,379,000.00 | 3,379,000.00 | - | 100.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1 | 800,195,000.00 | 719,899,993.49 | 80,295,006.51 | 89.97 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 131 | 669,452,100.00 | 668,845,200.00 | 606,900.00 | 99.91 |
| Улсын төсвөөс санхүүжих | 131001 | 669,452,100.00 | 668,845,200.00 | 606,900.00 | 99.91 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 132 | 71,540,200.00 | 50,914,793.49 | 20,625,406.51 | 71.17 |
| Орон нутгийн төсвөөс | 132001 | 71,540,200.00 | 50,914,793.49 | 20,625,406.51 | 71.17 |
| ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС | 133 | | | - | |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 120004 | 59,202,700.00 | 140,000.00 | 59,062,700.00 | 0.24 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1200042 | 140,000.00 | 140,000.00 | - | 100.00 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 1200043 | 59,062,700.00 | | 59,062,700.00 | 0.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 31 | 59,062,671.68 | 59,062,671.68 | - | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 31 | 59,062,671.68 | 8,680,630.49 | 50,382,041.19 | |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | 165 | 165 | 0 | 100 |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | | 1 | 1 | 0 | 100 |
| Төсвийн байгууллага | | 1 | 1 | 0 | 100 |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | | 22 | 22 | 0 | 100 |
| Удирдах ажилтан | | 1 | 1 | 0 | 100 |
| Гүйцэтгэх ажилтан | | 10 | 10 | 0 | 100 |
| Үйлчлэх ажилтан | | 11 | 11 | 0 | 100 |
| СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | | 135 | 135 | 0 | 100 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй нийт 3,479.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, 3,479.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 3,479.7 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 8,903.5 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. "Балансын урамшуулал олгох тухай" тус Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.09.24-ны өдрийн Б/29 дүгээр тушаалуудыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийн, няравт 1,105.0 мянган төгрөг нийт "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.1.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь 339.9 мянган төгрөг суутган 3,059.1 мянган төгрөгийг 21 ажилтанд олгохдоо суутган буюу ногдуулан төлөх 815.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна": 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|-----------------------------------|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Балансын урамшуулал олгосон | 1 | 2,664.00 | | | 1 | 2,664.00 | | |
| НДШ суутгаагүй буюу ногдуулаагүй. | 1 | 815.7 | | | 1 | 815.7 | | |
| Дүн | 2 | 3,479.70 | - | - | 2 | 3,479.70 | | |